



МАРК Р. ПЬО, ЭМЭЛГЭЙ, ЧИ ЮУНД УЙЛНА ВЭ?

Түүний амилалтыг гэрчлэх олон гэрч

“Би Шинэ Гэрээнд гардаг Аврагчийн амилсныг гэрчлэх гэрчүүд болох Петр, бусад төлөөлөгч, цэвэр ариун Магдалын Мариа болон бусад гэрчид итгэдэг. Би Мормоны Номонд гардаг Өгөөмөр нутаг дахь төлөөлөгч Нифайд болон цугласан олны гэрчлэлд итгэдэг. Мөн би Иосеф Смит, Сидней Ригдон хоёрын Түүний талаар өгсөн олон гэрчлэлийн дараа “Тэр амьд бөлгөө! Учир нь бид түүнийг харсан” хэмээх энэхүү эцсийн эрин үеийн агуу гэрчлэлд итгэдэг. Бүхнийг харагч Түүний мэлмий дор би Назарын Есүс бол амилсан Гэтэлгэгч гэдгийг мөн Түүний амилалтын *үнэн бодит байдлын* бүх зүйлийг гэрчилж байна. Та нар мөн үүнтэй адил итгэл, тайтгарлыг олж авах болтугай.”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсон, “Есүс Христийн Амилалт,” 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 135.

Амьдралдаа хэрэгжүүлэх нь: Хэдийгээр бид Гэтэлгэгчийн амилсан, төгс бие махбодыг харсан хүмүүсийн дунд байгаагүй ч өнөөдөр Түүний гэрч болон зогсож чадна. Биднийг хэзээ ч мөн хаана ч байсан бай, Тэрээр амьдралын маань төвд үргэлж байсаар байх болно. Бид бусдыг өрөвдөж хайрлан, үйлчилж, бүгдэд номхон даруу зан ааш, нинжин сэтгэл, хүндлэл үзүүлж, сайн мэдээний гэрчлэлээ хуваалцах болгондоо Есүс Христийн жинхэнэ гэрч болон зогсдог билээ.

ГРЭГОЛСЭНИ “НАДТАЙ ХАМТ АЛХ” ЗУРГААС АВАВ, ХУУЛБАРЛАХЫГ ХОРИГЛОНО

Бид орь ганцаар алхах шаардлагагүй

“Христийн амилсны баярын үеэр мэдэрч болох гайхалтай тайтгарлуудын нэг нь Есүс цор ганцаараа тийм урт замыг туулсан учраас *бид* туулах шаардлагагүй болсон явдал юм. Түүний ганцаар хийсэн аялал нь бидэнд өөрсдийн богинохон замд Тэнгэр дэх Эцэгийн энэрэнгүй анхаарал халамж, биднийг хэзээ ч орхихгүй хайрт Хүүгийнх нь нөхөрлөл, Ариун Сүнсний төгс бэлэг, тэнгэр дэх тэнгэр элчүүд, хөшигний хоёр талд байх гэр бүлийн гишүүд, бошиглогч төлөөлөгч, багш, удирдагчид болон найз нөхдийг бидэнд авчирсан билээ. Есүс Христийн Цагаатгал болон Түүний сайн мэдээний Сэргээлтийн ачаар мөнх бус амьдралын аялалд дээр дурдсанаас гадна өөр олон хамтрагчийг бидэнд өгсөн. Хэдийгээр заримдаа бидэнд ганцаар мэт санагдах үе байдаг ч Калварийн толгод дээрээс биднийг хэзээ ч ганцаар, тусламжгүй үлдээхгүй гэсэн үнэнийг бүрэн дуугаар мэдэгдсэн болно. . . .

. . . Бид ‘ямар ч цагт мөн бүх зүйлд мөн [өөрсдийн] байж болох хаана ч үхэлд хүртлээ’ Есүс Христийн дэргэд зогсох болтугай. Учир нь Тэр үхэн үхтлээ цор ганцаар зогсож *байсан* ч ийнхүү итгэлтэйгээр бидний хажууд зогсож байсан юм.”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд, “Түүнтэй хамт хэн ч байсангүй,” 2009 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 97–98.

Амьдралдаа хэрэгжүүлэх нь: Энэ жилийн Христийн амилсны баяраар Аврагчийн эцсийн бөгөөд ганцаараа хийсэн аяллыг дурсан сана. Тэр Өөртөө байсан бүхнийг золиосолсон болохоор та болон энэ дэлхий дээрх бүх хүн цэвэр ариун болж, мөнх амьдралтай байж чадах болсон. Түүний төгс жишээнээс суралц. Түүнийг бодол санаандаа болон зүрх сэтгэлдээ хадгал. Та хэзээ ч ганцаараа биш гэдгийг үргэлж сана. Тэр Өөрийн эцсийн аяллыг орь ганцаар хийсэн болохоор таныг орхихгүй. Таныг гэсэн Түүний хайр хэмжээлшгүй бөгөөд хувиршгүй. Мөн таныг аялаа үргэлжлүүлэхэд Тэр танд амар амгалан, тайтгарал, найдварыг өгөхөд бэлэн байдаг. Түүний Цагаатгалын бэлэг үүрдийнх бөгөөд энэ нь танд өгөгдсөн. ■

Дээгүүр өнгөрөх баяр Христийн амилсны баярыг ойлгоход бидэнд хэрхэн тусалдаг болохыг [lds.org/go/41817](https://www.lds.org/go/41817)-оос үзнэ үү.

